



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: [Selenge@audit.gov.mn](mailto:Selenge@audit.gov.mn)  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

ОРХОН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМД

2024. 08. 06 № ГНАГ-2024/13 -ИТА-НН-08  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Монгол Ардын намын Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Орхон сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Орхон сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
ОРХОН СУМЫН МАН-ЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.06.05

Орхон сум  
4317143998  
МЮА0065 9055436

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД  
Эрүүл иргэн -Амьдралын суурь

- “Элэг бүтэн Монгол”, “Хавдаргүй Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, эрүүл хүүхэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Иргэн бүрийг жил бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо шинжилгээнд тогтмол хамрагддаг ажлыг зохион байгуулна.
- Их эмчийг эрүүл мэндийн төвд тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нийгмийн баталгааг хангах бодлого баримтална.
- Эргэлтийн эмийн санг өргөтгөх, эмийн хангамжийг сайжруулах бодлого баримталж эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.
- Уламжлалт эмчилгээний нэр төрөл тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- Алслагдсан малчид, иргэдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусlamж, үйлчилгээнд шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, хурдавчилсан оношилгоо, өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусlamжийн чанарыг дээшлүүлнэ.
- Үндны усны савыг эко болгох хөдөлгөөн өрнүүлж “Эрүүл хүнс-Эрүүл иргэн” хөтөлбөр хэрэгжүүлж иргэдийн хоол хүнсний хэрэглээ, амьдралын хэв маягт зөв хэвшил суулгах нөлөөллийн ажлыг жил бүр зохион байгуулна.
- Нарийн мэргэжлийн эмчээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах эмч, эмнэлгийн ажилтнуудад орон нутгийн төсвөөс олгох урамшууллын бодлогыг хэрэгжүүлж, тогтвортой суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОЛОВСРОЛ-ТӨЛӨВШИЛ

- Хүүхэд багачуудыг улсын болон олон улсын чанартай тэмцээн уралдаан, олимпиадад оролцож гаргасан амжилтын үзүүлэлтээр урамшуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Сурагчдыг зуны амралтаараа гадаад хэл түлхүү сурх, хүссэн спортоороо хичээллэх, үндэсний спортууд болон өв соёлоо дээдлэн залгамжлах эрүүл

чийрэг монгол хүн болон төлөвшүүлэх нөлөөллийн ажлыг орон нутгийн хэмжээнд тогтмол зохион байгуулна.

- 2.3 Спорт заалаар дамжуулан хүүхэд багачуудыг олон төрлийн спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлж өсвөрийн тэмцээн уралдаануудыг зохион байгуулж тамирчдын залгамж халааг бэлтгэхэд анхаарна.
- 2.4 Өсвөр үеийнхнийг эх оронч үзэлтэй, их түүхээ судалж, ~~улаамжлалт өв соёлоо~~ дээздэлсэн, “Зөв хүн” болгон төлөвшүүлэх, бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургах ажлыг зохион байгуулна.
- 2.5 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 2.6 Орон нутагт дутагдалтай багшийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах хүсэлтэй Орхон сумын харьят оюутныг дэмжих бодлого баримтална.


4317143998  
МЮА0065 9055436

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОЁЛ УРЛАГ Соёлтой иргэн-Ёс суртахууны суурь**

- 3.1 Монгол хүн-Монгол ахуй-Монгол соёл-Монгол урлаг” бодлогыг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэхэд соёлын төвийн ажлыг чиглүүлнэ.
- 3.2 Цантын цаасны үйлдвэрийн туурь, люваанжалбо бурхны орчныг тохижуулж дотоод гадаадын аялал жуулчлалын маршрутад оруулах түүхийг сэргээх нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
- 3.3 Соёлын биет бус өв, язгуур урлаг, үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх хүүхэд багачуудад өвлүүлэх зорилгоор үндэсний урлагийн бага наадмыг жил бүр зохион байгуулна.
- 3.4 Цахим номын сангийн сан хөмрөгийн үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 3.5 Соёл урлагийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хүүхэд багачуудыг дугуйланд хамруулна.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БИЕЙН ТАМИР, СПОРТ Эрүүл, чийрэг иргэн – Идэвхтэй амьдрал**

- 4.1 Спорт заалыг түшиглэн иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир, сонирхсон спортоороо хичээллэх сонирхлыг төрүүлэх, эрүүл чийрэг амьдралыг төлөвшүүлэх, дасгал хөдөлгөөн хийх дадлыг суулгах зорилгоор биеийн тамир, спортын олон төрлийн секц, дугуйланг насны хязгааргүй тогтмол хичээллүүлнэ.
- 4.2 Аймгийн болон бүсийн чанартай, нэрэмжит, нээлттэй тэмцээн уралдааныг жилд 1-с доошгүй удаа сумандaa зохион байгуулж хүүхэд багачуудад спортын үлгэр дуурайлал авах өсөж хөгжих боломжийг бүрдүүлнэ.



- 4.3. Иргэдийн дунд “Хөдөлгөөн-Эрүүл Мэнд” уриан дор спортын олон төрөлт бага наадмыг жил бүр зохион байгуулна.
- 4.4 Биеийн тамир, спортын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах, шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэд ая тухтай орчинд биеийн тамир спортоор хичээллэх боломжийг дээшлүүлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

### Хөдөлмөрч иргэн – Элбэг хангалуун амьдрал

- 5.1. Хоршоологчид болон өрхийн аж ахуй үйлдвэрлэгчдийн нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд бодлогоор дэмжиж томоохон суурин газруудад мах, ногоо, цагаан идээний брендийн нэрийн дэлгүүр байгуулах ажлыг зохион байгуулна.
- 5.2 Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэруудтэй нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих чиглэлд хамтарч ажиллана.
- 5.3. Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид болон улсын чанартай авто зам дагуух худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд үйлчилгээний орчин нөхцөлөө сайжруулахад хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.4 Зорилтот бүлгийн өрхүүдэд амьжирааг дэмжих төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.5 Бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, технологийн дэвшилийг ашиглах саналыг холбогдох байгууллагад уламжилна.
- 5.6 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.
- 5.7 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.8 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.9 Ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажлын бээлий, хэрэглээний уут, шуудай зэргийг үйлдвэрлэх жижиг цех байгуулсан аж ахуйн нэгж, иргэдийн бүтээгдэхүүний борлуулалтыг хөдөө аж ахуйн салбарын ажилтнууд, аж ахуй нэгжүүд, ойролцоо томоохон үйлдвэруудтэй холбох ажлыг зохион байгуулна.
- 5.10 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

### 6.1 Аялал жуулчлал

- 6.1.1 Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тогтвортой хөгжлийн гуравдагч салбар болгон хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

- 6.1.2 Сум орон нутгийн хэмжээнд түүх дурсгалын болон байгалийн үзэсгэлэнт газруудыг хамарсан аялал жуулчлалын маршрут гаргаж, гадаад дотоодын жуулчдад морин аялал хийх иргэн аж ахуй нэгжийг дэмжиж ажиллана.
- 6.1.3 Малчны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орлогыг нэмэгдүүлэх, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгын хүрээнд төв суурийн газрын иргэд, хүүхэд багачууд болон дотоод гадаадын жуулчдыг монгол малчны хотонд монгол ахуйд суралцангaa, амрах орчныг бүрдүүлэх айл өрхийг дэмжиж, сурталчилж гэрээсээ орлого олох боломжийг бүрдүүлж ажиллана.
- 6.1.4 Улсын чанартай авто замын зорчигч урсгал-Орхон голыг түшиглэн "street foods" /цагаан идээ, эко хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, шорлог, бургөр, зайдас, пицца, шарсан загас, утсан загас, далайн гаралтай бүтээгдэхүүн, сүүн зайрмаг гэх мэт / түргэн хоол, ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах үйлчилгээний нэгдсэн цэг байгуулж иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

## 6.2 Газар тариалан

- 6.2.1. Төмс хүнсний ногоог жилийн дөрвөн улиралд хэрэглэгчдийн шаардлагад нийцүүлэн ууталж савлан бэлтгэн нийлүүлэх иргэдийг нэгтгэж томоохон худалдааны төвүүдийн нийлүүлэлтийг хангах замаар "Шийрийн төмс" бренд үүсгэн борлуулалтын үнийн тогтвортой байдлыг хангана.
- 6.2.2 Стратегийн хүнсний зориулалттай болон жимс жимсгэнэ, мөөг зэрэг шинэ нэр төрлийн таримлын тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 6.2.3 Хүнсний ногоо хадгалах орчин үеийн шаардлагад нийцсэн 2500 тонн багтаамжтай зоорь барих ажлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 6.2.4 Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, зөвхөн атаршсан газрыг эргэлтэд оруулах замаар талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 6.2.5 Тариалангийн газрын хөрсний үржил, шимиийг алдагдуулахгүй байх малын хөлөөс хамгаалах ажлыг малчин-төр-тариаланч гэсэн гурвалсан гэрээ байгуулж дотоод зөрчлийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 6.2.6 Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимиийг алдагдуулахгүй байх талаар газар эзэмшигчтэй хамтарч ажиллана.

## 6.3 Мал аж ахуй

- 6.3.1 Сумын хэмжээнд бий болсон малын үүлдэр, генийн санг хамгаалж, цөм сүргийг тогтвортой өсгөн малын ашиг шимиийг нэмэгдүүлэх эцэг малыг сайжруулах, төрөлжих бодлого баримтална.
- 6.3.2 Мал, амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг дүрэм журам, стандартын дагуу чанартай зохион байгуулна.
- 6.3.3. Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, нэгдмэл байдлыг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- 6.3.4. Бэлчээрийн даацтай уялдуулж, малын тоо, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийн мэрэгч амьтад, шавжтай тэмцэх, малын бэлчээр, хадлан, тэжээлийг хамгаалах, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж ажиллана.
- 6.3.5 Дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахиа шувуу, зөгийн аж ахуй эрхлэх иргэн ААН-ийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 6.3.6 “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малчин өрхийн амьжиргааг дэмжин, мал, малын гаралтай түүхий эд, мах махан бүтээгдэхүүн, сүү цагаан идээ, арьс шир боловсруулах цех байгуулах дундын хоршооллыг байгуулж мах сүү цагаан идээний нэрийн дэлгүүрийг төв суурин газруудад ажиллуулах замаар мөнгөн урсгалыг тогтмолжуулж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

### **ДОЛООДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН**

- 7.1 Сумын төв болон бусад газарт хөрсний эвдрэлд орж элсэн манхан, эрэг ганга үүссэн газруудыг үе шаттайгаар засварлаж моджуулах, эзэнжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 7.2 Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах, ойн хомстол, доройтлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 7.3 Сумын нутаг дэвсгэрт үлийн цагаан оготнын тархцын судалгааг явуулж бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 7.4. Хууль бус ан агнуур, модны хулгайг таслан зогсоож байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
- 7.5 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.
- 7.6 Шахмал түлш үйлдвэрлэх, түлээ нүүрсний цэг байгуулах иргэн ААН-ийг дэмжиж ажиллана.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ. ШУДАРГА ЗАСАГЛАЛ, ГАДААД ХАРИЛЦАА Иргэнд ойрхон төрийн үйлчилгээ**

- 8.1 Төр, иргэний нийгэм, ТББ, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 8.2 Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, орон нутгийн засаглалын тогтвортой, шударга, бүтээлч байдлыг хангана.
- 8.3 Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал, урамшуулалт олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоог төлөвшүүлнэ.

- 8.4 Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний чухал хэсэг болгон хэвшиүүлж, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ.
- 8.5 Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажил, гарга хэмжээнд дотоод хяналтыг чанартай гүйцэтгэж үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлнэ.
- 8.6 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 8.7 Төрийн албан хаагчийн тасралтгүй сурч хөгжих бололцоог бүрдүүлж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.
- 8.8 Төрийн алба, эрүүл мэнд, боловсрол, аялал жуулчлал, мал аж ахуй, газар тариалан, төмс хүнсний ногоог дэмжсэн гадаад бодлогыг хэрэгжүүлнэ.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. СУМ ОРОН НУТГИЙН ШИНЭЧЛЭЛ**  
**Сэтгэл тайван иргэн – Аз жаргалтай амьдрал**

- 9.1 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг зохион байгуулж, иргэдийн санаачилгыг дэмжиж төсөл хэрэгжүүлэх замаар дахин боловсруулж болох хуванцар “Хог хаягдал төвлөрүүлэх цэг”-ийг байгуулна.
- 9.2 Хүүхэд залуучуудын талбайг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тохижуулж олон төрөлт тоглоом, элсний волейболын талбай нэмж байгуулна.
- 9.3 Дархан -Эрдэнэтийн зам дагуу цахилгаан эрчим хүч татах ажлыг өргөжүүлж холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 9.4 Хөдөө аж ахуйн гражийн хойд уулзвар, хойд уулзвараас Эрүүл мэндийн төв хүртэлх 1 км замыг хатуу хучилттай авто зам, явган хүний замаар холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 9.5 Сумын төв, 42-р зөрлөг, Шийрт гэрэлтүүлгийн ажлыг аймаг, сумын хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэн бүрэн ашиглалтад оруулна.
- 9.6 Дархан Эрдэнэтийн зам дагуу болон сумын төв дотор “Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах”, иргэдийн өмч хөрөнгийг хамгаалах чиглэлээр шаардлагатай газруудад гадна орчны камержуулалтын ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 9.7 Төрийн албан хаагчдын байрыг их засварт оруулах ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлэнэ.
- 9.8 Ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх, хамгаалахад иргэдийн оролцоог дээшлүүлнэ.
- 9.9 Сумын төвд шаардлагатай газар үерийн хамгаалалтын далан, хур тунадасны ус зайлуулах суваг, хоолойг байгуулна.
- 9.10 Дархан Эрдэнэтийн авто замаас сумын төв хүртэлх 5км авто замын засварын ажлыг хийж шаардлага хангасан замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлнэ.
- 9.11 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн

хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.

**Сэлэнгэ аймгийн Орхон сумын МАН-ын Хорооноос 2024 оны Сэлэнгэ аймаг, Орхон сумын ИТХ-ын сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа сум, орон нутгаа хөгжүүлэх энэхүү зорилтуудыг та бид хамтран хэрэгжүүлж, ахмад үеийнхээ хөдөлмөрч, дайчин, шударга уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Орхон нутгаа "ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ".**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**